



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар A/02

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

ЭМСайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн 505 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Эмнэлгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, түр хадгалах, халдваргүйтгэх, тээвэрлэх устгах журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Тархвар судлаач эмч /Б.Мөнхчимэг/-т үүрэг болгосугай.
3. Хог хаягдлын менежментийг стандартын түвшинд хэрэгжүүлж байнгын хяналт тавьж ажиллахыг Тасгийн эрхлэгч нарт даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ерөнхий эмчийн 2015 оны 7-р сарын 24-ний өдрийн А/25 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЭМЧ



Д.БААСТ

D: Erunkhii emchiin tushaal

Ерөнхий эмчийн 2018 оны 01 сарын 01 өдрийн

142 тоот тушаалын
Т. - р хавсралт



Хог хаягдлыг ангилах, цуглуулах, түр хадгалах, халдваргүйтгэх, тээвэрлэх устгах журам

Нэг. Зорилго нь эмнэлгийн хог хаягдлын менежментийг стандартын түвшинд явуулахад оршино.

Хоёр. Нийтлэг зүйл

2.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах тээвэрлэх, боловсруулах, устгаж заавар батлах тухай 2017 оны 12 сарын 12-ны өдрийн 505 тоот тушаалыг дагаж мөрдөнө. Эмнэлэг хар, шар, хүрэн уут, аюулгүй хайрцагаар тасралтгүй хангана.

2.2. Хогийн уут дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1 Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, хлор агуулаагүй нийлэг материалаар хийгдсэн байна.

2.2.2. Уут нь 7 микроноос багагүй зузаантай байна (ISO 7765:2004).

2.2.3. Халдвартай, эмгэг, хурц үзүүртэй хог хаягдлын уут, сав нь шар өнгөтэй, эмийн болон эсэд нөлөөтэй, химийн, цацраг идэвхит хог хаягдлын уут хүрэн өнгөтэй байна.

2.2.4. Уутны гадна талд хог хаягдлын шинж чанараас хамаарч тусгайлсан "Биоаюултай" таних тэмдгүүдийг харагдахуйц өнгөөр, томоор хэвлэсэн байна.

2.3. Хогийн сав, уут тогтоогч дараахь шаардлага хангасан байна. Үүнд:

2.3.1. Зориулалтын хогийн сав эсвэл уут тогтоогчийг ашиглана.

2.3.2. Хогийн сав нь шингэн нэвчихгүй, хуванцар, металл зэрэг материалаар хийгдсэн зузаан, бат бөх, таглаатай, хөлөөр дарж онгойлгодог байна. Хэрэв овор ихтэй бол дугуйтай байна.

2.3.3. Уут тогтоогч нь өндөр нягтралтай хуванцар материалаар хийгдсэн, таглаатай байх бөгөөд овор ихтэй бол дугуйтай байж болно.

2.3.4. Гарч байгаа хаягдлын хэмжээнээс хамаарч багтаамж нь 10 – 250 л байх бөгөөд 3/4-т "Анхаар! Энэ түвшнээс дээш дүүргэж болохгүй" гэсэн тэмдэглэгээ, "Биоаюултай" таних тэмдэгтэй байна.

2.3.5. Хог хаягдалтай уут, савыг хог хаягдал үүсч байгаа газар байршуулж, хаягдлыг ангилан ялгах талаар заавар, санамжийг бичиж тавьсан байна.

Гурав. Хог хаягдлыг ангилах, цуглуулах заавар

3.1. Хар өнгийн тэмдэглэгээтэй хогийн сав, уутанд энгийн хог хаягдлыг хийнэ. Үүнд: Албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гал тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газраас гарч буй сав, баглаа боодол, гар угаасны дараа хэрэглэсэн нэг удаагийн алчуур, эм, урвалжийн гадна талын сав баглаа боодол, нэг удаагийн зүүний хуванцар таглаа (бохирлогдоогүй) хоол хүнсний үлдэгдэл зэрэг хаягдлуудаас гадна шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг ашиглаж болох дахивар нөөц хамаарна.

3.2. Шар өнгийн тэмдэглэгээтэй хогийн сав, уутанд халдвартай хог хаягдлыг хийнэ. Үүнд: Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад биологийн шингэнээр (биеийн өтгөн, шингэн ялгадас, цэр, шүлс, цус) бохирлогдсон зүйлс, цус, цусан бүтээгдэхүүн болон лабораторид үүсэх хүн, амьтанд халдвар дамжуулах эрсдэл бүхий эмгэг төрөгчөөр бохирлогдсон өсгөвөр, тэжээлт орчин, тэдгээрийг хэрэглэхэд ашиглагдаж буй багаж хэрэгсэл, вакцин, биобэлдмэл, судалгаа шинжилгээнд ашигласан туршилтын мал, амьтны сэг зэм гэх мэт хог хаягдал хамаарна. Мөн эмгэг хог хаягдал болох мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, эхэс, зулбадас, хүн, амьтны цогцос, эдийн шинжилгээний лааны тосон цутгамаг, судалгаа шинжилгээнд ашигласан мал, амьтны сэг зэм зэрэг нь эмгэг хог хаягдалд хамаарна.

3.3. Хүрэн өнгийн тэмдэглэгээтэй хогийн сав, уутанд, Химийн бодисын хог хаягдал, Эмийн болон эсэд хортой хог хаягдал хийнэ. Үүнд: эмийн болон эсэд хортой хог хаягдал болох хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг зэрэг нь эмийн хог хаягдалд, хавдрын эмчилгээний үед хэрэглэгддэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдэл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг, хэрэглэсэн зүү, тариур зэрэг нь эсэд хортой эмийн хог хаягдалд хамаарна. Мөн Химийн бодисын хог хаягдалд эрүүл мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээ, шинжилгээ, судалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагааны явцад үүссэн хатуу, шингэн, хийн байдалтай химийн бодисууд, хүнд металл агуулсан хэрэгслүүд хамаарна. Үүнд:

- Лабораторийн хаягдал (урвалж оношлуур, химийн бодисын хаягдал г.м.)
- Уусгагч,
- Рентген зургийн хальс бэхжүүлэх, боловсруулах уусмал,
- Формальдегид, этилен оксид,
- Хугацаа дууссан химийн бодисууд,
- Шингэн хий агуулж байсан сав, бортого
- Хэрэглээнээс гарсан халууны шил, даралтны аппарат
- Эмнэлгийн зарим төрлийн багаж хэрэгсэл,
- Өдрийн гэрэл, зай зэрэг болно.

3.4. Аюулгүй хайрцганд Хурц үзүүртэй, иртэй хог хаягдлуудыг хийнэ. Үүнд: Халдвартай эсэхээс үл хамааран хатгах, зүсэх гэмтэл учруулах эрсдэлтэй бүх төрлийн зүү, тариур, өндөг цоологч, наалдацын шил, мэс заслын хутга, ир, хагарсан ампул, түүнтэй адилтгах шилэн эд зүйл, пипетка, хуруу шил гэх мэт бүх төрлийн хог хаягдал хамаарна.

3.5. Зөөх, тээвэрлэх нөхцлийг хангасан, түгжээтэй, бат бөх тугалган хамгаалалт бүхий зориулалтын саванд Цацраг идэвхит хог хаягдлыг хийнэ. Үүнд: Цацраг идэвхит хог хаягдалд эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, судалгааны ажлын явцад үүсэх ионжуулагч цацраг бүхий радионуклидууд агуулсан цацраг идэвхит шинж чанар бүхий хатуу, шингэн, хийн хаягдал хамаарна.

Дөрөв. Хог хаягдлыг цуглуулах

- 4.1. Тасаг нэгжийн ээлжийн сувилагч нар тусгай хог хаягдлыг заавар журмын дагуу ангилж цуглуулан хар, шар, хүрэн тэмдэглэгээтэй уут, сав, аюулгүй хайрцагт хийнэ.
- 4.2. Аюулгүй хайрцаг нээсэн огноо, тасаг нэгжийн нэрийг тавина. Хог хаягдлыг ангилан ялгалтыг тухай бүр тасгийн менежер сувилагч хянаж хяналтын дэвтэрт тэмдэглэл хөтөлнө.
- 4.3. Тасгийн хог үүсэх цэг бүрээс ээлжийн сувилагч нар шар хүрэн, аюулгүй хайрцагтай хогийн битүүмжлэн цуглуулна.

Тав. Тусгай хог хаягдлыг түр хадгалах

- 5.1. Битүүмжилсэн тусгай хог хаягдлыг ээлжийн сувилагч нар манаач нарт хүлээлгэн өгч, тэмдэглэлийн хуудсанд гарын үсэг зуруулна.
- 5.2. Тусгай хог хаягдлыг хүлээлцэхэд манаач аюулгүй нээсэн огноо, тасаг нэгжийн нэрийг шалгаж авна. Хэрэв хаяглалт байхгүй тохиолдолд Тархвар судлаач эмчид мэдээлж, хогийн хүлээж авахаас татгалзана.
- 5.3. Сувилагч нар тусгай хог хаягдлын өрөөнд хогийг хаяхдаа шидэхгүй эмх замбараагүй тавихгүй, зориулалтын шар хогийн саванд хийж, таглаж тавина.
- 5.4. Эмгэг хог хаягдал нь биологийн идэвхтэй байдаг тул хадгалах тусгай нөхцөлд буюу +3 +8°C-т хөргүүрт хийж тавина.
- 5.5. Манаачид хүлээлгэж өгөөгүй тусгай хог хаягдлыг ил задгай орхихыг шууд хориглоно.
- 5.6. Хүлээлгэж өгөөгүй тохиолдолд тусгай хог хаягдалд манаач нар гар хүрэх шаардлагагүй бөгөөд Тархвар судлаач эмчид яаралтай мэдээлнэ.

Зургаа. Тээвэрлэх устгах

- 6.1. Тусгай хог хаягдлыг эмнэлэгт халдваргүйтгэх шаардлагагүй.
- 6.2. Лабораториос гарч байгаа цус, шээс гэх мэт халдвартай шингэн хог хаягдлыг перкисийн 3% уусмалд хийж 1-2 цаг байлган урьдчилан халдваргүйжүүлж бохирын шугаманд нийлүүлнэ.
- 6.3. Ээлжийн манаач нар тусгай хог хаягдлыг жинлэн, гарын үсэг зуруулж тээвэрлэгч байгууллагад хүлээлгэн өгнө.
- 6.4. Зориулалтын шар сав, хөргүүрийн бүрэн бүтэн байдал, тоо ширхэгийг ээлжийн манаач нар хариуцна.
- 6.5. Үйлчлэгч нар ахуйн хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт хаяна.

Долоо. Тусгай хог хаягдлын өрөөг цэвэрлэж, халдваргүйтгэх арга

- 7.1. Хүүхдийн тасаг 1,5,9-р сард, насанд хүрэгчдийн тасаг 2, 6, 10-р сард, оношлогоо үйлчилгээний тасаг 3, 7, 11-р сард, мэс заслын тасаг 4,8,12-р сард тусгай хог хаягдал түр хадгалах өрөөний цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэнэ.
- 7.2. Сар бүрийн 5-ны өдөр Тархвар судлаач эмчийг байлцуулан дараагийн тасагт хүлээлгэн өгнө.
- 7.3. Өрөөний цэвэрлэгээнд шаардлагатай халдваргүйтгэлийн уусмалыг халдварын эрсдэл өндөртэй бүсийг цэвэрлэх найрлагаар зааврын дагуу найруулж хэрэглэнэ.

Найм. Тусгай хог хаягдлын өрөөний ажиллах цагийн хуваарь

8.1. Ээлжийн манаач нар өглөө 07:50-08:00 цаг хүртэл, үдээс хойш 16:00-16:30 хүртэл цагийн хооронд эмнэлгийн тусгай хог хаягдал түр хадгалах байрыг нээж, хогийг хүлээн авна.

Ес. Хүлээх хариуцлага

9.1. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, түр хадгалах, халдваргүйтгэх, тээвэрлэх, устгах журмыг зөрчсөн эмч, эмнэлгийн ажилтнуудыг ХСХАлбаны хурлаар авч хэлэлцэн хариуцлага хүлээлгэнэ.